



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/53.


Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын хийн дасгал шигшээ тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын хийн дасгалын шигшээ тэмцээнийг 2018 оны 11 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд “Буянт Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 6.400.000 /Зургаан сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД


Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын хийн дасгалын шигшээ тэмцээн зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 19 x 2 x 50.000 төг = 1.900.000 төг 19 x 2 x 40.000 төг = 1.520.000 төг 19 x 2 x 30.000 төг = 1.140.000 төг	4.560.000
2.	Шүүгчдийн ажлын зардал: /5 хүн x 2 өдөр x 50.000 төг/	500.000
3.	Өргөмжлөл	100.000
4.	Медаль 114 ш x 10.000=1.140.000 төг	1.140.000
5.	Анонс, цом	100.000
ДҮН:		6.400.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны *10 сүүлээр* сарын *20* ны өдрийн
А/33 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын
VII наадмын хийн дасгалын шигшээ
тэмцээн шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | Х.Оюунбилэг |
| 2. Шүүгч | А.Болорцэцэг |
| 3. Шүүгч | А.Болдмаа |
| 4. Шүүгч | Ж.Чулуунцэцэг |
| 5. Шүүгч | Н.Оюунгэрэл |